



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/143/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Зүүнбүрэн сум 2025 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
	Аудитыг гүйцэтгэсэн: "Ари файнэнс аудит" ХХК Захирал Д.Ариунаа Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-17
4. Аудитын тайлан	17-20
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19-20
5. Аудитын илрүүлэлт	21-22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
УСНББОУС стандарт	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ШУ	Шинжлэх ухаан
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ЗҮҮНБҮРЭН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.УРАНБОДОЛ ТАНАА

2025.02.25

№ 007-0025/143/НА-007-7143

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Боловсрол шинжлэх ухааны яам, Орон нутгийн хөгжлийн сан, Боловсролын газар, Дезерет олон улсын байгууллагаас нийт 786,909.4 мянган төгрөгийн үнэ бүхий сурах бичиг, зөөврийн компьютер, телевизор, сурагчийн ширээ, сандал, хөгжим, гал тогооны тавилга, тоног төхөөрөмж зэрэг үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус газрын тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 5 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

432502241

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.2 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайл анд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	306,720,138.24	404,922,506.09
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	159,849,627.63	230,803,405.11
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	159,849,627.63	230,803,405.11
3121	Төгрөг	159,849,627.63	230,803,405.11
31211	Төрийн сангийн харилцах	159,849,627.63	230,803,405.11
33	АВЛАГА	249,339.31	1,774,316.68
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	249,339.31	1,774,316.68
35	БАРАА МАТЕРИАЛ	146,621,171.30	172,344,784.30
351	Түүхий эд материал	24,579,829.69	31,665,267.69
35110	Тусгай зориулалттай материал	24,522,729.69	31,608,167.69
35130	Эм боох материал	57,100.00	57,100.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	2,303,000.00	1,040,000.00
354	Хангамжийн материал	119,738,341.61	139,639,516.61
35410	Бичиг хэргийн материал	6,536,220.00	13,200,195.00
35420	Аж ахуйн материал	64,665,001.61	71,808,901.61
35430	Сэлбэг хэрэгсэл	1,752,000.00	1,752,000.00
35460	Хүнсний материал	156,000.00	6,249,300.00
35470	Бусад хангамжийн материал	46,629,120.00	46,629,120.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,502,267,865.97	3,152,955,190.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,502,267,865.97	3,152,955,190.46
392	Биет хөрөнгө	2,448,694,532.53	3,099,465,190.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,220,028,417.90	2,726,612,019.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	(209,686,650.96)	(264,680,814.91)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(9,708,333.36)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	315,002,049.43	415,185,174.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	(138,753,922.51)	(109,212,030.48)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	197,262,595.07	229,963,125.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	(47,529,770.80)	(40,482,291.39)
39209	Зам, гүүрийн байгууламж	31,515,231.46	31,515,231.46
39210	Хуримтлагдсан элэгдэл	(11,457,981.00)	(14,967,776.88)
39214	Бусад үндсэн хөрөнгө	91,429,346.81	91,429,346.81
39215	Хуримтлагдсан элэгдэл	(40,981,155.96)	(20,492,227.44)
39217	Ном	37,012,206.45	40,032,933.95
393	Биет бус хөрөнгө	53,573,333.44	53,490,000.16
39301	Програм хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(166,666.56)	(249,999.84)
39303	Бусад биет бус хөрөнгө	53,490,000.00	53,490,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,808,988,004.21	3,557,877,696.55
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	503,515.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	503,515.00
413	Өглөг	-	503,515.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,808,988,004.21	3,557,374,181.55
51	Засгийн газрын хувь оролцоо	2,808,988,004.21	3,557,374,181.55

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,041,714,376.20	1,041,714,376.20
51101	Өмч: - төрийн	1,041,714,376.20	1,041,714,376.20
512	Хуримтлагдсан үр дүн	764,089,779.32	1,512,475,956.66
51210	Өмнөх үеийн үр дүн	764,089,779.32	1,289,103,380.60
51220	Тайлант үеийн үр дүн	-	223,372,576.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,003,183,848.69	1,003,183,848.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,808,988,004.21	3,557,877,696.55

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,469,761,437.72	2,893,783,939.71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,991,888.00	805,569,802.37
120	Нийтлэг татварын бус орлого	10,991,888.00	805,569,802.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,991,888.00	5,509,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,140,788.00	2,557,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	2,951,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,711,100.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		786,909,464.37
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		13,151,338.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,315,305,135.66	2,088,214,137.34
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,119,990,400.00	1,877,909,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,119,990,400.00	1,877,909,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	195,314,735.66	210,304,637.34
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	195,314,735.66	210,304,637.34
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,552,630,823.18	2,145,397,762.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,552,630,823.18	2,145,397,762.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,495,167,663.18	2,087,845,762.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	881,319,723.85	1,346,709,899.64
210101	Үндсэн цалин	629,714,073.90	864,368,704.46
210102	Нэмэгдэл	216,846,613.26	440,162,465.18
210104	Урамшуулал	34,759,036.69	42,178,730.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,675,351.48	166,356,232.26
210201	Тэтгэврийн даатгал	76,637,861.66	114,373,775.61
210202	Тэтгэмжийн даатгал	9,016,219.13	13,608,579.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,425,618.94	6,678,889.92
210204	Ажилгүйдлийн даатгал	1,684,865.92	6,293,874.12
210205	Эрүүл мэндийн даатгал	16,910,785.83	25,401,113.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	171,522,135.66	202,915,552.34
210301	Гэрэл, цахилгаан	13,878,659.17	19,448,015.00
210302	Түлш, халаалт	142,329,076.49	168,220,537.34

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	15,314,400.00	15,247,000.00
2105	Нормативт зардал	95,820,070.00	105,271,100.00
210502	Хоол, хүнс	95,820,070.00	105,271,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,892,600.00	7,892,600.00
210604	Урсгал засвар	7,892,600.00	7,892,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,691,917.00	32,896,771.25
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,034,000.00	1,520,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,657,917.00	31,376,671.25
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	221,245,865.19	225,803,606.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,950,800.00	57,642,417.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,613,000.00	10,209,250.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	189,682,065.19	157,951,939.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,463,160.00	57,552,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,463,160.00	57,552,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	57,463,160.00	57,552,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(82,869,385.46)	748,386,177.34
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	525,013,601.28
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	525,013,601.28
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	(525,013,601.28)
5	НИЙТ ҮР ДҮН	(82,869,385.46)	223,372,576.06

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,319,585,923.66	2,093,723,137.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,280,788.00	5,509,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,280,788.00	5,509,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,280,788.00	5,509,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,140,788.00	2,557,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	2,951,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,315,305,135.66	2,088,214,137.34
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,119,990,400.00	1,877,909,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,119,990,400.00	1,877,909,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	195,314,735.66	210,304,637.34
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	195,314,735.66	210,304,637.34
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,376,990,097.30	2,001,039,559.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,376,990,097.30	2,001,039,559.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,317,223,937.30	1,944,750,559.86

**Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	881,411,018.52	1,347,914,529.26
210101	Үндсэн цалин	630,295,525.19	873,392,873.12
210102	Нэмэгдэл	216,369,394.14	433,055,239.31
210104	Урамшуулал	34,746,099.19	41,466,416.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,833,396.12	166,676,580.01
210201	Тэтгэврийн даатгал	76,743,497.66	114,705,623.36
210202	Тэтгэмжийн даатгал	9,029,321.13	13,605,291.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,436,099.94	6,677,245.67
210204	Ажилгүйдлийн даатгал	1,687,486.92	6,293,883.87
210205	Эрүүл мэндийн даатгал	16,936,990.47	25,394,536.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	171,522,135.66	202,412,037.34
210301	Гэрэл, цахилгаан	13,878,659.17	18,944,500.00
210302	Түлш, халаалт	142,329,076.49	168,220,537.34
210303	Цэвэр, бохир ус	15,314,400.00	15,247,000.00
2105	Нормативт зардал	95,976,070.00	111,364,400.00
210502	Хоол, хүнс	95,976,070.00	111,364,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,362,600.00	7,892,600.00
210604	Урсгал засвар	8,362,600.00	7,892,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,691,917.00	35,934,771.25
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,034,000.00	1,520,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,657,917.00	34,414,671.25
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,426,800.00	72,555,642.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,132,800.00	56,301,217.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,294,000.00	16,254,425.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,766,160.00	56,289,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,766,160.00	56,289,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	59,766,160.00	56,289,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(57,404,173.64)	92,683,577.48
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	60,382,800.00	21,729,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	60,382,800.00	21,729,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	60,382,800.00	21,729,800.00
223001	Бусад хөрөнгө	60,382,800.00	21,729,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(60,382,800.00)	(21,729,800.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(117,786,973.64)	70,953,777.48
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		159,849,627.63
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	159,849,627.63	230,803,405.11

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,041,714,376.20	1,003,183,848.69	764,089,779.32	2,808,988,004.21
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	525,013,601.28	525,013,601.28
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,041,714,376.20	1,003,183,848.69	1,289,103,380.60	3,334,001,605.49
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,041,714,376.20	1,003,183,848.69	1,289,103,380.60	3,334,001,605.49
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,041,714,376.20	1,003,183,848.69	1,289,103,380.60	3,334,001,605.49
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	223,372,576.06	223,372,576.06
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,041,714,376.20	1,003,183,848.69	1,512,475,956.66	3,557,374,181.55

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,246,526,100.00	2,022,769,359.86	223,756,740.14	90.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,246,526,100.00	2,001,039,559.86	245,486,540.14	89.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,182,176,900.00	1,944,750,559.86	237,426,340.14	89.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,528,820,400.00	1,347,914,529.26	180,905,870.74	88.17
210101	Үндсэн цалин	1,012,954,900.00	873,392,873.12	139,562,026.88	86.22
210102	Нэмэгдэл	501,488,700.00	433,055,239.31	68,433,460.69	86.35
210104	Урамшуулал	14,376,800.00	41,466,416.83	(27,089,616.83)	288.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	191,102,600.00	166,676,580.01	24,426,019.99	87.22
210201	Тэтгэврийн даатгал	129,949,700.00	114,705,623.36	15,244,076.64	88.27
210202	Тэтгэмжийн даатгал	15,288,200.00	13,605,291.02	1,682,908.98	88.99

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	7,644,100.00	6,677,245.67	966,854.33	87.35
210204	Ажилгүйдлийн даатгал	7,644,100.00	6,293,883.87	1,350,216.13	82.34
210205	Эрүүл мэндийн даатгал	30,576,500.00	25,394,536.09	5,181,963.91	83.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,412,200.00	202,412,037.34	162.66	100.00
210301	Гэрэл, цахилгаан	18,944,500.00	18,944,500.00	-	100.00
210302	Түлш халаалт	168,220,700.00	168,220,537.34	162.66	100.00
210303	Цэвэр бохир ус	15,247,000.00	15,247,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	114,228,200.00	111,364,400.00	2,863,800.00	97.49
210502	Хоол, хүнс	114,228,200.00	111,364,400.00	2,863,800.00	97.49
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,892,600.00	7,892,600.00	-	100.00
210604	Урсгал засварын	7,892,600.00	7,892,600.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,257,100.00	35,934,771.25	3,322,328.75	91.54
210801	Бусад ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,037,400.00	1,520,100.00	(482,700.00)	146.53
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	38,219,700.00	34,414,671.25	3,805,028.75	90.04
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	98,463,800.00	72,555,642.00	25,908,158.00	73.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,584,200.00	56,301,217.00	25,282,983.00	69.01
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,879,600.00	16,254,425.00	625,175.00	96.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,349,200.00	56,289,000.00	8,060,200.00	87.47
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	64,349,200.00	56,289,000.00	8,060,200.00	87.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	64,349,200.00	56,289,000.00	8,060,200.00	87.47
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	64,349,200.00	56,289,000.00	8,060,200.00	87.47
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		21,729,800.00	(21,729,800.00)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,252,035,100.00	2,093,723,137.34	158,311,962.66	92.97
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,036,221,300.00	1,877,909,500.00	158,311,800.00	92.23
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,036,221,300.00	1,877,909,500.00	158,311,800.00	92.23
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	210,304,800.00	210,304,637.34	162.66	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	210,304,800.00	210,304,637.34	162.66	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,509,000.00	5,509,000.00	-	100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,557,500.00	2,557,500.00	-	100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,951,500.00	2,951,500.00	-	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	159,849,627.63	(159,849,627.63)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	230,803,405.11	(230,803,405.11)	-

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	58	58	-	100.00
620001	Удирдах ажилтан	4	4	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	36	36	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	18	18	-	100.00
620004	Гэрээт ажилтан			-	
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО	568.00	568.00	-	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургууль нь “Хамтаараа хөгжсөн, зөв дадал хэвшилтэй хүүхэд болгон төлөвшүүлэх” зорилгыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлон ажилласан байна

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сурч, хөгжих хүнлэг энэрэнгүй, амар тайван орчин бүрдүүлж, ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн, эерэг хандлага, соёлыг төлөвшүүлэх.
- Ээлжит хичээлийн чанар, үр өгөөжийг сайжруулж, сурагчдын өөрийгөө илэрхийлэх, асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлж, шинжлэх ухаанч хандлагыг төлөвшүүлэх.
- Цахим системд суурилсан сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлж, сурагчдыг чадваржуулах.
- Сурагчдын авьяас чадварыг нээн хөгжүүлэх дугуйлан секцийн хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн оролцоо, хамгааллыг хангах.
- Багшийн хөгжил, манлайлал, цахим орчинд ажиллах чадварыг сайжруулах.
- Эцэг эх, олон нийтийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, эрхийн актуудыг мөрдлөг болгон хэрэгжүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургууль нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 748,889.69 мянган төгрөгөөр буюу 26.6 хувиар өссөн байна.

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан
Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	159,849.6	230,803.4	70,953.8
Авлага	249.3	1,774.3	1,525.0
Бараа материал	146,621.2	172,344.8	25,723.6
Үндсэн хөрөнгө	2,502,267.9	3,152,955.2	650,687.3
Нийт хөрөнгө	2,808,988.0	3,557,877.7	748,889.7
Өр төлбөр	-	503.5	503.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,808,988.0	3,557,374.2	748,386.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,808,988.0	3,557,877.7	748,889.7

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.
Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 230,803.41 мянган төгрөг байгаа нь төсвийн хэмнэлттэй холбоотой байна.
- Авлага дансны үлдэгдэл 1,774.3 мянган төгрөг болж 1,525.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь НДШ-ийн авлага үүсгэснээс шалтгаалсан байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 172,344.8 мянган төгрөг болж 25,723.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 238,761.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, нийт 13,151.3 мянган төгрөг (аймгийн Боловсролын газраас 7,085.4 мянган төгрөг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2,880.9 мянган төгрөг, төгсөгчдөөс 3,185.0 мянган төгрөгийн үнэ бүхий багш хөгжлийн төвийн тоног төхөөрөмж, сурах бичиг, биеийн тамирын хэрэглэгдэхүүн) -ийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, 226,189.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,152,955.2 мянган төгрөг болж 650,687.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 21,729.8 мянган төгрөгийн принтер, таблет, зурагт худалдан авч, 117,922.3 мянган төгрөг (БШУЯ-аас 23,926.3 мянган төгрөг, аймагийн Боловсролын газраас 1,261.2 мянган төгрөг, аймагийн ОНХС-аас 73,573.5 мянган төгрөг, Дезерет ОУБ-аас 17,401.8 мянган төгрөг, төгсөгчдөөс 1,759.5 мянган төгрөгийн үнэ бүхий сурах бичиг, зөөврийн компьютер, телевизор, сурагчийн ширээ, сандал, хөгжим, гал тогооны тавилга, тоног төхөөрөмж) -ийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, аймагийн төсвийн хөрөнгө оруулалтаар хичээлийн байранд 443,534.8 мянган төгрөгийн, дотуур байранд 64,170.0 мянган төгрөгийн их засвар хийгдсэнийг капиталжуулсан, 161,312.3 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгасан, сумын ИТХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 16 дугаар тогтоолоор 3,747.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан, 154,234.1 мянган төгрөгийн элэгдэл нэмж байгуулснаас шалтгаалсан байна.

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Тайлант онд 503.5 мянган төгрөгийн гэрэл цахилгааны зардлын өр төлбөр үүсгэсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2024 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,801,488.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналаас 109,185.5 мянган төгрөгөөр бууруулан 1,692,303.0 мянган төгрөгөөр баталсан боловч төсвийн жилийн дундуур төсөвт зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 2,036,221.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 210,304.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,557.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 2,951.0 мянган төгрөг зэрэг нийт 2,252,035.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу улсын төсвөөс 1,877,909.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 210,304.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,557.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 2,951.5 мянган төгрөг, нийт 2,093,723.1 мянган төгрөг төвлөрүүлж, 2,022,769.3 мянган төгрөгийг зарцуулж, 223,756.7 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,022,769.3 мянган төгрөг буюу 90.0 хувьтай байгаа нь үдийн цай хөтөлбөрийн зардлыг 8,060.2 мянган төгрөгөөр, дотуур байрны үйлчилгээний зардлыг 17,576.3 мянган төгрөгөөр, багш ажилчдын мэргэшил дээшлүүлэх зардлыг 3,166.40 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 189,913.2 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагааны зардлыг 2,599.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226 - Байр ашиглалтын үйлчилгээ	3,970.5	3,970.5	0.0	100.0
2	80233 Хүүхэд хамгаалал	3,864.2	3,864.0	0.2	100.0
3	80312 - Сургалт семинар	2,649.0	2,649.0	0.0	100.0
4	81605 - Эрүүл мэндийг дэмжих	4,029.0	4,029.7	0.0	100.0
5	81801 - Үдийн цай хөтөлбөр	64,349.2	56,289.0	8,060.2	87.5
6	81806-Дотуур байрны үйлчилгээ	353,072.5	335,496.2	17,576.3	95.0

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

7	81816 Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	26,202.0	26,200.8	1.2	100.0
8	81823 - Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	11,966.2	8,799.8	3,166.4	73.5
9	81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,537,133.8	1,347,220.6	189,913.2	87.6
10	81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагаа	12,035.7	9,436.5	2,599.2	78.4
11	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	2,726.5	2,776.4	49.9	101.8
12	81848-Сурах бичиг түрээс	1,037.4	1,520.1	482.7	146.5
13	81875 Сургалтын нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	5,387.6	2,665.6	2,722.0	49.5
14	81827 Бичиг үсгийн боловсрол	7,797.0	7,546.5	250.5	96.8
Дүн		2,036,221.3	1,812,464.7	223,756.6	89.0
15	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	210,304.8	210,304.6	0.2	100.0
Нийт		2,246,526.1	2,022,769.3	223,756.8	90.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “*Чиглэл хүргүүлэх тухай*” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг үндсэн дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дотуур байрны хүүхдийн хоол болон сургуулийн үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Дотуур байрны хүүхдийн хоол бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах 101,578.7 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер шалгаруулалтад Марат ХХК болон сургуулийн үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах 60,588.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад Өгөөж баян ноён уул ХХК тус тус шалгарч гэрээ байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулах болон анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой зөвлөмж өгсөн болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Ари файнэнс аудит” ХХК-ийн аудитор Б.Туяа гүйцэтгэж, захирал Д.Ариунаа анхан шатны чанарын хяналтыг, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ари файнэнс аудит” ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,552,630.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 15,526.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 28 төрлийн 167 мэдээллийг хугацаанд нь байршуулсан бол цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний хавсралт файлууд /шийдвэрийн хуулбар/-ыг байршуулаагүй, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг завсрын аудитад хамруулаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 628.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 378.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 249.3 мянган төгрөгийн авлага үүсгэсэн 1 зөрчилд албан шаардлага өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад өр төлбөр үүсгэсэн зөрчил давтагдан 50.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	378.9	1	378.9	100.0
Албан шаардлага	1	249.3	-		-
Нийт дүн	2	628.2	1	378.9	50.0

Өмнөх аудитаар төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас авлага үүсгэсэн зөрчилд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн нягтлан бодогч Ц.Уянга сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.

Аудитаар 5,509.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн үйл ажиллагаанаас орох орлого /1200041/, туслах үйл ажиллагаанаас орох орлого /1200042/-ыг салгаж бүртгээгүй байна.

Аудитаар нийт 4 зөрчил¹ илрүүлж, **6,228.5** мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 1,525.0 мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1 дэх “...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу нягтлан бодогч Ц.Уянгад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.2 Зөвлөмж

1. Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Номын болон спорт заалны түрээсийн орлогын анхан шатны баримтын бүрдэл дутуу, аккурэл сууриар бүртгээгүй зэрэг нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сул байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Орлогыг аккурэл сууриар бүртгэж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

2. Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт 2: Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч 1,752.0 мянган төгрөгийн сэлбэгийн тооллогыг хийгээгүй, тооллогын бүртгэл, тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1. "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн тооллогыг хийхдээ тооллогын бүртгэл, тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Орлогын ангилал буруу бүртгэсэн	1	5,509.0			1	5,509.0	1	5,509.0				
Дүн	1	5,509.0			1	5,509.0	1	5,509.0				

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт-ны тоо	Тоо	Дүн	
Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй авлага үүсгэсэн	1	1,525.0								1	1		
Үндсэн болон туслах үйл ажиллагаанаас орох орлогыг аккурэл сууриар бүртгээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу.	1	2,951.5					1	2,951.5					
Сэлбэгийн тооллогыг хийгээгүй, тооллогын бүртгэл, тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй.	1	1,752.0					1	1,752.0					
Дүн	3	6,228.5					2	4,703.5	1	1			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний хавсралт файлууд /шийдвэрийн хуулбар/ оруулаагүй байна.	1						1	
Дүн	1						1	



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 146/А1850385

Сүхбаатар

00А-2025/143/НА-СТА-ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 1,525.0 мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ... бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.2 -д "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан нягтлан бодогч Ц.Уянгад холбогдох хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Ц.Уранбодолд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ч.ЭНХТУЯА

Д.АРИУНАА



432504437

